

тойрон жигд хянаж чаддаг болж, хилийн зөрчлийн тухай мэдээлэл төвдөө хурдан ирж, түүний мөрөөр авах арга хэмжээг шуурхай болгоно" гэж тус тус заасан билээ.

Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн улсын хилийн хамгаалалтыг улам боловсронгуй болгох эрэл хайгуулын явцад хилийн цэрэг дахин байгуулагдсан 1960-ад оноос хил хамгаалалтад ашиглагдаж ирсэн хилийн постыг улам хөгжүүлж шинэ агуулгаар баяжуулан ашигласнаар илүү үр дүнд хүрч болно гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Хошууч генерал П.Даш

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТЭМДГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Монголчууд эрт дээр үеэс нутаг бэлчээр, засаг захирагааныхаа нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоож, онцгойлон таних тэмдгээр тэмдэглэж ирсэн түүхтэй билээ.

Хилийн цэсийг тэмдэглэхдээ уулын хяр, орой, гуу жалга, гол мөрөн, худаг, булаг шанд, сондгой хад, чулуу, ганц мод зэрэг газар орны янз бүрийн онцлогийг ашиглахаас гадна хилийн цэсийг улам тодорхой болгохын тулд нэмэгдэл овоо тэмдэг босгодог байжээ.

Монгол Улсын хилийн тэмдгийн үүсэл нь 1727 оны Буурын гэрээгээр тогтоогдсон хилийн дагуух овоонуудаас эхлэлтэй гэж үзэж болно. Эдгээр хилийн овоо нь одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дахь "Дундын овоо" түүнээс баруун, зүүн тийш хилийн дагуу босгосон хос чулуун болон шороон овоонууд юм. Хилийн овоонууд нь дан, хосоор байх ба ихэвчлэн чулуун болон шороон овоо байдаг.

Манж Оросын хооронд байгуулсан Буурын гэрээгээр Монгол Улсын хойд хилийн дагуу Дундын Овооноос зүүн тийш Тарваган Дахын Овоо хүртэл 58 овоо, баруун тийш Монгол Шарын Даваа хүртэл 18 овоо босгосон байна. Тарвагатайн гэрээгээр Алтайн Таван Богд Уулын 4104.0 тоот өндөрлөгөөс Асгатын давааны хярын орой хүртэл 6 овоо, бүгд хилийн 86 овоог мөн босгожээ.

Буурын гол болон Тарвагатайн Гэрээгээр тогтоосон хилийн баримт бичигт хилийн овоонуудыг хаана босгосон, дэс дараанд оруулж дугаарласан, хэлбэр, төрлийг нь тодорхойлсон байдаг. Харин хилийн нэг овооноос дараагийн овоо хүртэл хилийн шугамын байршлын талаар, зай хэмжээг хэрхэн тусгасан нь тодорхойгүй байдаг тул

цаашид архивын материалаас судлах нь чухал юм.

Хилийн харуулууд хариуцсан хэсгийнхээ овоонуудыг байнга арчлан хамгаалж, сэргээн засварладаг байсан бөгөөд зарим овоог тахих, хөрш улстайгаа хамтран "Эв модны наадам" хийх зэрэг зан үйл үйлддэг байжээ. Энэ нь хилийн овоог байнгын сэргээлттэй байлгахад чухал нөлөө үзүүлэхээс гадна хилийн овоог хөрш улсуудын хил орчмын оршин суугчдаас хайрлан хүндэтгэхэд ихээхэн тустай байв.

Судалгаанаас үзэхэд Монгол, Оросын хилийн Тувагийн хэсэг болох Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг Хул азаргын нурууны ус хагалбарын хавтгай хэсэгт Монгол, Тувагийн хил орчмын ардууд засаг захиргааныхаа хилийг тогтоохдоо морь, үхэр тэрэгний мөр гарган түүний дагуу хүний алхамын хэмжээтэй гадас хатгасан нь (одоо хүртэл байгаа) хэсэг газарт өнөөгийн хилийн шугамын байршилтай давхцаж байна.

Хилийн түүхэн овоо нь тухайн цагтаа маш олон хүний хөдөлмөр, хөлс зарцуулж боссон нь одоо илт байдаг ба он цаг улиран өнгөрөх бүр газрын хөрсөнд эдгэрэн бүдгэрч, ой тайгатай хэсэгт зарим хилийн овоо нь олдохгүй болжээ.

Ахмад хилчин Б.Цэдэн-Иш, Т.Ламжав нар Монгол, Зөвлөлтийн хилийн гэрээг 1974 онд байгуулахаас өмнө Манж, Оросын 1727 оны Буурын Гэрээгээр тогтоосон хилийн дагуух түүхийн овоонуудыг олж тогтоох газар орны судалгааны ажил хийсэн бөгөөд Өвөр хаданцын голын чиглэлд цөөхөн хэдхэн овоог олоогүй гэдэг.

1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялснаар Орос улстай ах дүүгийн найрамдалтай болж хойд хилийн харуулуудаа татан буулгасны уршгаар хилийн овоо тэмдгүүдээ манай улсын талаас хайхрахаа больж арчлан хамгаалах ажил орхигдсон байна.

Үүний нэг тод жишээ бол Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг Монгол, Оросын хилийн Бүргэдэй уулан дахь 813 дугаар тэмдгийн дэргэд байгаа хилийн 1 дүгээр хос овоог сүйтгэсэн, Дорнод аймгийн Чулуунхорхот сумын нутаг Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн уулзвар гэгдэх Тарваган Дахын хилийн 58 дугаар овооны байршлыг өөрчилж чулууг урагш зөөсөн явдал юм.

Хилийн 1 дүгээр овоог Оросын тал 1930-аад оны үед буулгаж чулуугаар нь харуулын байр барьсан гэлцдэг. Нотлох баримт нь энэ овооны ором дээр "1937 г.Г.И" гэсэн сийлбэртэй мод байдаг.

Хожим нь 1960-аад оны дунд үед Сэлэнгэ аймгийн орон нутгийн МАХН-ын болон МХЗЭ-ийн байгууллагад ажиллаж байсан хүмүүсийн санаачилгаар Бүргэдэй уулын өвөрт Октябрын хувьсгалын 50 жилийн

ойд зориулж "ОКТЯБРЬ-50", МХЗЭ-ийн 45 жилийн ойд зориулж "МХЗЭ-45 мандтугай" гэсэн бичлэгүүдийг уг овооны нурсан чулуугаар зөөж хийсэн нь одоо хүртэл газар дээрээ мэдэгддэг.

Хилийн 58 дугаар овоо буюу Тарваган Дахын овоо нь түүхийн баримтаараа одоо ОХУ-ын нутагт байх бөгөөд Оросууд Япончуудын эсрэг энэ чиглэлд цэргийн бэхлэлт барьж байх үед уг түүхийн овооны байршлыг өөрчилж ойролцоогоор 7 км урагшлуулж одоогийн 645.0 тоот өндөрлөгт чулуун овоонуудыг нь зөөсөн байж болох баримт нь энэ овоон дээр "Коммун 1937 г" гэсэн бичигтэй чулуу байгаа юм.

1930-40-өөд оны үед Оросын цэргийн газрын зургийнхан газрын зураг үйлдэхдээ энэ өндөрлөгийг Тарваган Дахын овоо гэж нэрлэн зурагт оруулжээ.

Монгол Улс хөрш улстайгаа хилийн хэд хэдэн хэсэгт хил тогтоох, түүнийг тогтоон тэмдэглэх явцад хилийн тэмдгийн янз бүрийн шинэ хэлбэрийг сонгон тавьж байжээ. Үүнд Сэлэнгэ аймгийн Алтанбулгийн чиглэлд 1930 онд Монгол, Зөвлөлтийн хооронд байгуулсан хилийн Протоколоор хилийн дагуу модон багана босгож байсан бол 1936 онд Монгол, Баргын хоорондох хилийн маргааныг зохицуулж байгуулсан хэлэлцээрээр хилийн дагуу Монголын тал модон багана, Баргын тал чулуун баганыг одоогийн Дорнод аймгийн Халх голыг чиглэлд босгож байжээ. Эдгээр хилийн тэмдгийн загвар ХЦУГ-ын музейд хадгалагдаж байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн газрын зургийг 1930-аад оноос Оросын цэргийн газрын зургийн мэргэжилтнүүд анхлан хийсэн бөгөөд Монгол Оросын хилийн дагуу газар орны нэрийг газрын зурагт тусгахдаа манай талаас туйлын хариуцлагагүй хандсан нь илт байдаг. Жишээ нь Увс аймгийн Баруун туруун сумын чиглэлд хилийн шугам дайран өнгөрч байгаа Янгир толгойг "Бузлаг уул", Гүзээ уулыг "Хэцэг уул", Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын чиглэлд Тэнгис давааг "Монгол Шарын даваа" гэх мэтээр одоо Оросын нутагт байгаа уулын нэрийг зөөж тавьсан нь тэр үеийн 1:200000, 1:500000-ны масштабын газрын зураг дээр байдгийг санахад илүүдэхгүй.

Энэ мэтээр хилийн дагуух газар орны нэрийг будлиантуулсан нь хожим нь улсын хилийг тогтоох, тогтоон тэмдэглэх (делемитац, демаркац) үед хоёр талын комиссуд маргах эх үүсвэр болж байжээ. Хилчид бид хамгаалж буй хилийн хэсгийнхээ хилийн дагуух газар орны нэрийг цагийн явцад өөрчлөхгүй байх, шинээр дураараа нэр өгөх явдлаас ямагт сэргийлж байх нь чухал. Улсын хилийг тогтоох, түүнийг газар дээр нь тогтоон тэмдэглэх, хилийн шугамыг шалгаж тодотгох ажилд оролцсон манай талын зарим хүмүүс хилийн судалгаа,

мэдлэггүй байсан дутагдал архивын материалаас харагддагийг хойч үеийн хилчиддээ сануулахад илүүдэхгүй бизээ.

Монгол улс 1958 онд ОХУ-тай Тувагийн хэсэгт хилийн Гэрээ байгуулж 1959-1960 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх ажил (демаркац) явагдаж хоёр талаас хүлээн зөвшөөрсөн загварын хилийн тэмдэг босгожээ. Энэхүү хилийн тэмдгийн загварыг Монгол Улс ЗХУ-ын хооронд 1976 онд байгуулсан хилийн Гэрээгээр 1977-1979 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх үед хэрэглэсэн байна.

Монгол, Хятадын хооронд 1962 онд байгуулсан хилийн Гэрээгээр 1963 онд улсын хилийг газар дээр нь тогтоон тэмдэглэх үед Хятадын талтай тохирсон өөр загварын хилийн тэмдгийг тавьсан байгаа. Манай улс хил залгаа ОХУ, БНХАУ-тай хилийн шугамыг тэмдэглэхдээ хилийн тэмдгийн өөрийн гэсэн стандарт загвар байсангүй, ЗХУ, БНХАУ-тай тохирсноор одоогийн загварыг хэрэглэсэн байна.

ОХУ, БНХАУ 1991 онд хилээ газар дээр нь тогтоон тэмдэглэж хилийн асуудлаа шийдвэрлэсэн нь манай улсын хувьд хилийнхээ баруун, зүүн уулзварын асуудлыг шийдвэрлэх таатай нөхцөл бүрэлдсэн юм.

Гурван улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 1994 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

Гурван улсын хилийн зүүн уулзварын цэг 645.0 тоот өндөрлөг Тарваган Дахын овоон дээр байх хилийн тэмдгийн загварыг тохирсон байна.

Увс нуурын эрэгт босгосон хилийн 124, 125 дугаар тэмдгүүдийн байршлыг Монгол Улс, ОХУ-ын хооронд улсын хилийг 1987-1995 онд шалгах үед Увс нуурын эрэг тэлснээс шалтгаалж дээрхи тэмдгийн байршил нь усанд автагдаж алга болсон. Ажлын явцад хилийн тэмдгийг нуурын эрэг дээр болгож зөөхөд хоёр улсын хооронд нутаг дэвсгэрийн асуудал гарах байсан тул Хамтарсан комиссоос дээрх тэмдгийн байршлыг өвлийн цагт тогтоон "Хөвөгч" тэмдэг тавьсан юм.

Ингэж Монгол Улсын хилийн дагуух тэмдгийн загвар, төрөл, хэлбэр өөрчлөгдсөөр ирлээ. Одоо манай улсын хилийн дагуу дараахь төрлийн хилийн тэмдгүүд байдаг. Үүнд :

А. Хилийн төмөр-бетонон багана.

Монгол-Оросын хилд:

- Үндсэн тэмдэг

- Усны тэмдэг
- Шилжилтийн тэмдэг
- Завсрын тэмдэг

Монгол-Хятадын хилд:

- Төрийн сүлдтэй хилийн цементэн багана
- Хилийн дангаар босгосон чулуун овоо тэмдэг
- Хилийн дангаар босгосон цементэн багана
- Хилийн дангаар босгосон цементэн суурьтай цементэн

багана

Б. Хилийн овоо

- Дундын овоо
- Дангаар босгосон овоо
- Хосоор босгосон овоо

В. Хөвөгч тэмдэг

Г. Гурван улсын хилийн уулзвар дээр гурван хөлтэй суурин дээр босгосон пирамид эдгээр болно.

Ахлах багш, дэд хурандаа Д.Шаравшагдар

Л.В. Потапов (Буриадын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн Газрын тэргүүн)

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТ-НИЙТ АРД ТҮМНИЙ ҮЙЛ ХЭРЭГ МӨН

Оросын Холбооны Улсын Монголтой хиллэдэг Буриадын хилийн хэсгийн өнөөгийн нөхцөл байдал нь Буриад улсын удирдлагын сэтгэлийг нэлээд түгшээж байдаг юм. Юу гэвэл Буриадын нутаг дэвсгэрээр дайран гарч буй Монголтой хиллэдэг 1275 км хилийн хэсгийн 680 км нь цэргийн хүч хэрэгслээр халхлагдаж хамгаалагдаагүй учраас жилд үйлдэгдэж буй улсын хил түүний дэглэмийн зөрчлийн 70 илүү хувь нь энэ хэсгээр гарч тэдгээрийн дийлэнхи хувийг малын хулгай, контрбанд зэрэг хууль бус үйлдлүүд эзэлж байна.

Контрбандын үйл ажиллагаа хууль бусаар хил дамнуулан гуравдагч оронд гаргах оросын бараа түүхий эдийн хэмжээ нэмэгдсээр байна.